



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

᠒᠐᠒᠒ оны 1᠒ сарын ᠒3 өдөр

Дугаар ᠑/257

Мандалговь

Тамгын газрын нийт албан хаагчдыг
эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт
хамруулахад зардал гаргах тухай

Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3.3 дахь заалт, байгууллагын дотоод журмын 3.14.13 дахь заалт, Тамгын газрын ажилтан, албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн 3.4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2022 оны үндсэн ба туслах үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө давсан орлогоос 20,000,000 (Хорин сая) төгрөгийг албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулахад зарцуулсугай.

2. Албан хаагчдын нэрсийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3. Урьдчилан сэргийлэх үзлэгийн багцын үнийг эрэгтэй албан хаагчдад 247.000 (Хоёр зуун дөчин долоон мянга), эмэгтэй албан хаагчдад 243.000 (Хоёр зуун дөчин гурван мянга) төгрөгөөр тооцож үзлэгийн үнийн саналыг гуравдугаар хавсралтаар баталсугай.

4. Албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулахад зарцуулагдах 20,000,000 (Хорин сая) төгрөгийг нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас гарган зарцуулахыг нягтлан бодогч (М.Янжиндолгор)-т зөвшөөрсүгэй.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Л.ДОРЖБАТ

4822150653